



**НИЙСЛЭЛИЙН ЗАСАГ ДАРГЫН ХЭРЭГЖҮҮЛЭГЧ АГЕНТЛАГ  
ТЭЭВРИЙН ГАЗРЫН ДАРГЫН  
ТУШААЛ**

2017 оны 06 сарын 19 өдөр

Дугаар #153

Улаанбаатар хот

Нийтийн тээврийн үйлчилгээний  
чиглэлийг шинээр нээх тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж түүний удирдлагын тухай хуулийн 33 дугаар зүйлийн 33.5 дахь хэсэг, Автотээврийн тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.1.4, 8 дугаар зүйлийн 8.4 дэх хэсэг, Нийслэлийн Засаг даргын 2016 оны А/928 дугаар захирамжаар батлагдсан Нийслэлийн Тээврийн газрын “Дүрэм”-ийн 2.5.3, 3.1.19 дэх заалтыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Баянзүрх дүүргийн 19, 22 дугаар хорооны иргэдийн зорчих эрэлтийг үндэслэн Ч64 “Цагаан даваа-Офицеруудын ордон-Монгол кино үйлдвэр” чиглэлийн үйлчилгээг эхлүүлж, замналыг хавсралт ёсоор баталсугай.

2. Дээрх үйлчилгээг 2017 оны 06 дугаар сарын 21-ний өдрөөс мөрдүүлж эхлэх чиглэлийн зураглал, үйлчилгээний цагийн хуваарийг боловсруулж, нэгдсэн даалгаварт тусгахыг Тээврийн төлөвлөлт, технологийн хэлтэс /Д.Галбадрах/-т, нийтийн тээврийн үйлчилгээ эрхлэгч аж ахуйн нэгж, байгууллагатай гэрээ байгуулж, олон нийтэд хэвлэл мэдээллийн хэрэгслээр сурталчлан таниулах ажлыг зохион байгуулахыг Захиргааны удирдлага, санхүүгийн хэлтэс /Ц.Мөнхбат/-т, тухайн чиглэлийн үйлчилгээг зохион байгуулж, зохицуулалт хийх, хэвийн ажиллагааг хангуулж ажиллахыг Зорчигч тээврийн үйлчилгээний хэлтэс /Э.Баярт/-т, үйлчилгээг батлагдсан замналын дагуу явуулах, ажиллах цагийн хуваарийн мөрдөлтөд хяналт тавьж ажиллахыг Тээврийн хяналтын хэлтэс /Ц.Мягмар/-т тус тус даалгасугай.

3. Тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Орлогч даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч /Х.Булгаа/-д үүрэг болгосугай.

ДАРГА



Д.ОТГОНБААТАР

